



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 4/90

Хажуу шина ус

Г
Жишиг гудамжны хаалганы ажил хүлээн авах
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 74 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 оны 10 дугаар сарын 05-ний өдөр Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газар "Ган хийц" иргэний бүлэгтэй байгуулсан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар "Жишиг гудамжны хаалга"-ны ажлыг шинээр хийж гүйцэтгэх ажил үйлчилгээнд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийг хүлээн авах эрх бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үүнд:

Комиссийн дарга: Н.Өлзийтогтох (Тамгын дарга)

Гишүүд: Н.Ганбат (Санхүү албаны дарга)

Л.Батбаатар (Өрнөлт багийн засаг дарга)

Н.Хүрэлхуяг ("Ган хийц" иргэний бүлгийн ахлагч)

Г.Цэгц-Яруу (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)

2."Ган хийц" иргэний бүлэгтэй хүлээн авах ажлыг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн нэр төрөл, хэмжих нэгж, тоо ширхэг, хүчин чадал бүрээр нь акт үйлдэн хүлээн авч үндсэн хөрөнгөд бүртгэн авч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ө.МОНХ-АМГАЛАН



482201090